

**ЭРДЭНЭТ ХОТ БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 50 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН
ТҮҮХИЙН НОМ, ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛЬБОМ ХЭВЛҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2026.05.28.

Орхон аймаг

Захиалагчийн нэр:	“Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар”
Сонгон шалгаруулалтын нэр	Эрдэнэт хот байгуулагдсаны түүхт 50 жилийн ойд зориулсан түүхийн ном, гэрэл зургийн альбом хэвлүүлэх
Нийт төсөвт өртөг:	400,000,000 / Дөрвөн зуун сая /
Сонгон шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:	<i>Орхон аймаг. Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон</i> Утасны дугаар: [70352420]

Нэг. Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой нотлох баримт ирүүлэх эсэх: **“Туйм”**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээг баримт бичигт хавсаргаж ирүүлэх
2. Шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй тодорхойлолтыг ирүүлнэ.
3. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг авч ирүүлэх
4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх
5. Захирлын цахим иргэний үнэмлэх эсхүл лавлагааг эх хувиас сканердаж ирүүлэх
6. Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл ирүүлэх
7. Оролцогч нь баримт бичгийг бэлтгэж эх хувиар ирүүлэх ба материал тод гаргацтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.

Хоёр. Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: **“Шаардана”**

1. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. (Ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн нийлүүлэх бараа нь захиалагчаас шаардсан техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон баримтыг баталгаажуулан ирүүлнэ.)
2. Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. (Санал болгож буй үнэ нь аливаа бүх эрсдэл болон даатгал, НӨАТ зэрэг болзошгүй зардлуудыг багтаасан эцсийн үнэ байна.)
3. Нийлүүлэх барааны зургийг техникийн тодорхойлолтод заасан нэр төрөл бүрээр нэрийг нь бичиж өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх
4. **Стандарт:** Техникийн үзүүлэлтүүдийг бүрэн хангасан, үсгийн фонд болон өнгөний гаралт маш сайн байх. Номын нурууг оёсон байдал нь доод тал нь 5 жилийн хугацаанд өдөр тутмын хэрэглээг хангахуйц байна. Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох стандартын дагуу гүйцэтгэх тухай баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

5. **Баглаа, Боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Нийлүүлэгч тал хэвлэгдсэн номыг өөрийн зардлаар захиалагчид хүргэж, хүлээлгэж өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.
6. Оролцогч нь уг шалгаруулалтад шалгарсан тохиолдолд ирүүлсэн гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, төсөв, тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд ажлыг гүйцэтгэж барааг хүлээлгэж өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

Гурав. Ажил гүйцэтгэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ: Шаардана

Дөрөв. Оролцогч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: Шаардана

Оролцогч нь хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг Маягт 5-ын дагуу ирүүлнэ. /Маягтын дагуу үнэн зөв бөглөж ирүүлээгүй тохиолдолд татгалзах үндэслэл болно./

Тав. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”

Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: Татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг e-Mongolia системээс татаж, эх хувиар хавсаргаж ирүүлэх. Тайлбар: Өр төлбөртэй тохиолдолд тус оролцогчоос татгалзах үндэслэл болно.

- Борлуулалтын орлогын хэмжээ: Борлуулалтын орлогын хэмжээ: 2024, 2025 оны аль нэг жил борлуулалтын орлого батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх
- Түргэн хөрвөх хөрөнгөтэй холбогдох шаардлага: Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх

Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:

1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: [2024, 2025 оны санхүүгийн тайланг нотариатаар батлуулж өөрийн баримт бичигтээ эх хувиар хавсарган ирүүлэх. Санхүүгийн тайлангаас сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана]
2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: [Ижил төстэй ажлыг доод тал нь 5 удаа гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо: 2024, 2025 онуудад тус бүр доод тал нь 5 удаа ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх. Ижил төстэй ажлын нийлбэр нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байх]
3. Маягт 2-оор ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл, Маягт 3 -аар ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл маягтын дагуу бөглөж ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэж өгсөн актыг эх хувиас мөн тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолт, одоогийн ашиглалт хэрхэн байгааг тодорхойлсон ашиглагч байгууллагын тодорхойлолтыг **шалгаруулалт зарласан өдрөөс хойш авч эх хувиас** сканердаж ирүүлнэ.
4. Техникийн тодорхойлолтод заагдсан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах техник тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамжтай байх.
5. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ болон түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:
 - *Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн мэдэгдэл /Өөрийн гүйцэтгэсэн ажлын бодит орлого байх ба тухайн ажилд зориулан байршуулсан мөнгөн хөрөнгийг харгалзан үзэхгүй/*

- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ./Харилцагч банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий тодорхойлолт нь зохих журмын дагуу өмнө нь судлагдчихсан, шалгарсан тохиолдолд ямар нэгэн саадгүйгээр шууд олгох зээлийн мөнгөн дүн бүхий тодорхойлолт гэж ойлгоно.Шалгаруулалтад шалгарсан нөхцөлд судалж, зохих журмын дагуу зээл олгох боломжтой гэсэн утга бүхий тодорхойлолт, мөн Банк бус байгууллагын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүйг анхаарна уу./
 - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд
6. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг үнэлэхэд харгалзан үзэхгүй.

Зургаа.Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”

6.1. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлага:

№	Албан тушаал	Ажиллах хүчний тоо	Туршлага, тухайн мэргэжлээр ажилласан жил	Мэргэжил
1	Эх бэлтгэгч, дизайнер	5-аас доошгүй	2-оос дээш жил	Мэргэжлийн дизайнер, мэргэшсэн эх бэлтгэгч
2	Дэвтэрлэгээ хийгч, хэвлэгч, нугалаач, хавтан боловсруулагч	Тус бүр 3-аас доошгүй	2-оос дээш жил	Үйлдвэрлэлийн хэвийн тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангахуйц мэргэжилтэй, мэргэшсэн
3	Хайрцаг сав баглаа боодол идэвхжүүлэгч		2-оос дээш жил	Үйлдвэрлэлийн хэвийн тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангахуйц мэргэжилтэй, мэргэшсэн
4	Чанар шалгагч	3-аас доошгүй	2-оос дээш жил	Үйлдвэрлэлийн хэвийн тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангахуйц мэргэжилтэй, мэргэшсэн
5	Хүний нөөц	1	2-оос дээш жил	Хүний нөөцийн менежер
6	Хүргэлтийн жолооч	2	2-оос дээш жил	Үйлдвэрлэлийн хэвийн тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангахуйц мэргэжилтэй.
7	Бусад			

Дээрх ажилтнуудын жагсаалтыг маягт 2-д заасны дагуу гаргаж, тухайн ажлын даалгаврын гүйцэтгүүлж ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлага чадавхын мэдээллийг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.

✓ Ажлын туршлага чадавхын мэдээллийг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.

✓ Ажилласан жилийн туршлагыг нотлох Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн

лавлагааг “E Mongolia” –оос татаж, сканердаж ирүүлнэ.

- ✓ Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.
- ✓ Оролцогчийн үндсэн ажилтан болон хөлсөөр ажиллах ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн байх шаардлагатай. Бусад ажилтан буюу тухайн компанид нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй ажилтны хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан нийтийн албан тушаалтныг санал болгох тохиолдолд мөн хуулийн 18.5.3-т заасан удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийг хавсарган ирүүлнэ.
- ✓ Тухайн ажлын гэрээний гүйцэтгэлд дээрх санал болгосон ажилтнаас өөр ажилтнаар ажлын даалгаврыг гүйцэтгүүлсэн тохиолдолд илт худал мэдээлэл бүхий материал гэж үзэн эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл болохыг анхаарна уу.

6.2. Ажлын даалгаврыг гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана.” Маягт3

Гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн шаардлага:

- Офсет хэвлэлийн машин
- Дижитал хэвлэлийн машин
- Ном үдэх, хавтаслах төхөөрөмж
- Хатуу хавтас хийх төхөөрөмж
- Файлын бэлтгэл, компьютерын үзүүлэлт
- Нугалагч машин
- Цавуут үдэгч
- Emboss машин
- СТР машин

Олон тоогоор хэвлэх машин тоног төхөөрөмжтэй байх гэсэн шалгуурыг хангасан байна. /Гэрчилгээний хуулбар болон үзүүлэлтийг хавсаргах/

Долоо. Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдлийг Маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

Найм. Шалгаруулалтад шаардсан маягтуудыг үнэн зөв бөглөсөн болохыг баталж оролцогч этгээдийн гарын үсэг тамгаар баталгаажуулж ирүүлсэн байх. Дээрх шаардсан материалуудын аль нэг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг оролцогчоос татгалзах үндэслэл болно.

Шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа нь:

Огноо: **2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр**

Цаг: **10 цаг 00 минут**

Шалгаруулалтын материал хүлээн авах газрын хаяг: Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон, 108 тоот

ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

Урьдчилгаа төлбөр олгох эсэх: **Үгүй**

Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: **Үгүй**

Гүйцэтгэлийн баталгааны хувь хэмжээ: Тухайн жилд санхүүжих үнийн дүнгийн 3 хувь байна.

БАТЛАВ:
 ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
 ДАРГЫН ТАМГЫНГАЗРЫН
 ДАРГА

Б.ГАНЗОРИГ
 Б.ГАНЗОРИГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИН ДАХ ШААРДЛАГА

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. “Эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

№	Барааны тодорхойлолт	Цаасны үзүүлэлт	Нүүрний тоо	Хэвлэх тоо	Тайлбар
НЭГ ДҮГЭЭР ДЭВТЭР					
1	Номын нэр, лого	Клишей, алтлаг, хуурай даралттай	700	3000	Захиалагч эх бэлтгэл хийнэ. Үсгийн фонтыг гэрээ байгуулах үед хэлэлцэнэ.
	Номын хэмжээ	28*21 хэмжээтэй			
	Материал	Хавтас: Хатуу, бүрэлтгэй Дотор: 105 гр матт, Булан дугуй			
	Нуруу	Оёо наалттай			
	Гадна талын нүүр	Номин ногоон өнгийн Pantone өнгө /3272C/, зарим үсэг товгор			
Өнгө	4+4				
2	Хайрцаг	Алтлаг металл цаас, хайрцагны нурууны хэсэгт “Эрин зууны бахархал Эрдэнэт 50” гэсэн бичээсийг Монгол бичгээр бичсэн байна.	Ном, гэрэл зургийн альбом нэг дор багтах хэмжээтэй байна.	3000	-
3	Номын хавчуурга тууз		Номин ногоон өнгийн тууз	3000	-
ХОЁРДУГААР ДЭВТЭР (АЛЬБОМ)					
1	Номын нэр, лого	Клишей, алтлаг, хуурай даралт	600	3000	Захиалагч эх бэлтгэл хийнэ. Үсгийн фонтыг гэрээ байгуулах
	Номын хэмжээ	28*21 хэмжээтэй			
	Материал	Хавтас: Хатуу, Дотор: 128 гр матт, Булан дугуй			

	Хавтас	Хатуу хавтастай, бүрэлттэй			үед хэлэлцэнэ.
	Нуруу	Оёо наалттай			
2	Нүүр	Номин ногоон өнгийн Pantone өнгө /3272C/, зарим үсэг товгор		3000	
	Өнгө	4+4			
	Номын хавчуурга тууз	Номин ногоон өнгийн тууз			

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Түүхийн ном	3000	Ширхэг	<i>Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 20 хоногт</i>	<i>[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]</i>
2	Гэрэл зургийн альбом	3000	Ширхэг	<i>Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 20 хоногт</i>	<i>[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]</i>

-оОо-

ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ МАЯГТ

Маягтуудын жагсаалт:

- Маягт 1: Илгээх.....
- Маягт 2: Хүний нөөцийн мэдээлэл
- Маягт 3: Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл
- Маягт 4: Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл
- Маягт 5: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл
- Маягт 6: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл
- Маягт 7: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

илгээх

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[шалгаруулалтын нэр]** шалгаруулалтын үнийн санал шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү (цаашид “шалгаруулалт” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Шалгаруулалттай холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу материал нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо бичих]** өдрийн хугацаанд хүчинтэй байна.
5. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Шалгаруулалтад санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
7. Шалгаруулалтыг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, шалгаруулалтыг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:**

Хаяг:

Маягт 2: Хүний нөөцийн мэдээлэл

Тухайн ажилд санал болгож буй албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3: Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Тухайн ажилд санал болгож буй машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Тээврийн хэрэгсэл, машин механизмын улсын дугаар	Өмчлөл, эзэмшил /түрээс/-ийн аль нь болохыг тодорхой дурдах

Маягт 4: Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

№	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл, тайлбар
1.		
2.		
3.		
4.		
5.		